



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/868

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын хэсгийн байрны зардалд 450 000 төгрөг, Ахмад дипломатичид манай аймагт ажилласан зардал 770 000 төгрөг, Батлан хамгаалах яамны жанжин штабын ажлын хэсэгтэй хамтын ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан уулзалтын зардалд 407 970 төгрөг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 1 627 970 төгрөг /Нэг сая зургаан зуун хорин долоон мянга есөн зуун далан/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б ДҮГЭРЖАВ



02/04251